

## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2026/467/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас: 327734 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)  
Аудитын менежер Я.Алтанцэцэг  
Утас: 325093 Цахим хаяг: [altantsetsegya@audit.gov.mn](mailto:altantsetsegya@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Н.Баттогоо  
Утас: 325093 Цахим хаяг: [battogoon@audit.gov.mn](mailto:battogoon@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 356  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ  
ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД  
ХУРЛЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА  
А.УРАНБИЛЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд нийт 5,276.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 4,123.6 сая төгрөг, үүнээс гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх зардалд 1,400.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 1,188.3 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсвийн төслийг боловсруулахдаа тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагыг судалж, нөхцөл байдал, эрсдэлийг үнэлээгүй, шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй төсөв баталж, салбар зөвлөлд харьяалагдах байгууллагуудаар дамжуулан зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Нийслэлийн Баянзүрх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал 2025 онд нийт 8 удаа хуралдаж, нийт 40 асуудлыг хэлэлцэж, хэлэлцсэн асуудлаар нийт 34 тогтоолыг баталсан. Хуралдаанаар хэлэлцсэн нийтлэг асуудлыг онцолбол дүүргийн Засаг даргаас санаачилсан “Бидний ирээдүй 1000 тэтгэлэгт хөтөлбөр батлах тухай”, “Монгол ахуй-Аялал жуулчлалын кластер” төсөл зэргийг хэлэлцэж баталсан байна.

1126050539

C:\Users\narangua\Desktop\Бичиг хэргэ 2026\2026\word\yvesen bichig\Ungnet\_2026.docx

### **Бусад асуудал**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 5 зорилго, 18 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 92.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

төгрөгөөр/

Данс	Балансын үзүүлэлт	Тод руулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	4	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	5	27,888,214.23	4,462,286.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		434,769.23	262,286.70
<b>335</b>	<b>Бусад авлага</b>		27,453,445.00	4,200,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		27,453,445.00	4,200,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>		344,842,110.00	10,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал		344,842,110.00	10,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	6	532,179,362.00	48,784,165.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>		54,789,420.00	37,231,845.00
35110	Тусгай зориулалттай материал		54,789,420.00	37,231,845.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн		-	2,820,300.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>		477,389,942.00	8,732,020.00
35410	Бичиг хэргийн материал		4,931,030.00	425,000.00
35420	Аж ахуйн материал		9,441,950.00	3,341,100.00
35430	Сэлбэг хэрэгсэл		880,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал		3,160,000.00	-
35470	Бусад хангамжийн материал		458,976,962.00	4,965,920.00
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>904,909,686.23</b>	<b>63,246,451.70</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7	416,685,736.24	370,011,630.06
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		369,969,069.55	343,393,296.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл		49,500,000.00	49,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(29,562,500.00)	(37,812,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		529,934,773.60	478,100,501.60
39206	Хуримтлагдсан элэгдэл		(271,670,074.95)	(225,544,532.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		194,988,448.40	114,728,905.40
39208	Хуримтлагдсан элэгдэл		(104,512,744.48)	(36,337,411.52)
39209	Зам, гүүрийн байгууламж		1,540,000.00	-
39210	Хуримтлагдсан элэгдэл		(1,527,166.67)	-
39214	Бусад үндсэн хөрөнгө		4,300,000.00	4,300,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(3,021,666.35)	(3,541,666.31)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		46,716,666.69	26,618,333.40
39301	Програм хангамж		119,800,000.00	63,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(73,083,333.31)	(37,081,666.60)
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>416,685,736.24</b>	<b>370,011,630.06</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>1,321,595,422.47</b>	<b>433,258,081.76</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>1,279,306.22</b>	<b>136,174.67</b>

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	9	1,279,306.22	136,174.67
<b>413</b>	<b>Өглөг</b>		1,279,306.22	136,174.67
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		684,687.69	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>		594,618.53	136,174.67
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		594,618.53	136,174.67
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b><u>1,320,316,116.25</u></b>	<b><u>433,121,907.09</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		1,320,316,116.25	433,121,907.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		82,518,632.00	82,518,632.00
51101	Өмч:- төрийн		82,518,632.00	82,518,632.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		1,236,882,293.25	349,688,084.09
51210	Өмнөх үеийн үр дүн		1,236,882,293.25	1,236,882,293.25
51220	Тайлант үеийн үр дүн		-	(887,194,209.16)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		915,191.00	915,191.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b><u>1,321,595,422.47</u></b>	<b><u>433,258,081.76</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тод руулга	Өмнөх он	Тайлант он
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>6,175,817,885.61</b>	<b>4,470,402,508.73</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		1,427,300,000.00	346,749,416.01
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,427,300,000.00	346,749,416.01
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>		4,748,517,885.61	4,123,653,092.72
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		4,748,517,885.61	4,123,653,092.72
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>165,907,854.00</b>	<b>109,037,699.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		165,907,854.00	109,037,699.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		165,907,854.00	109,037,699.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	14,190,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		44,121,704.00	70,483,699.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		121,786,150.00	24,364,000.00
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2</b>	<b>6,341,725,739.61</b>	<b>4,555,076,207.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>5,690,305,098.59</b>	<b>5,442,270,416.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		4,379,547,878.59	5,313,806,576.89
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		890,142,991.00	1,260,762,991.32
210101	Үндсэн цалин		498,265,105.14	623,500,742.47
210102	Нэмэгдэл		139,702,168.86	249,616,928.95

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт		156,228,000.00	251,091,242.12
210104	Урамшуулал		80,517,717.00	63,821,420.67
210105	Гэрээт ажлын хөлс		15,430,000.00	72,732,657.11
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		114,247,418.20	156,048,356.34
210201	Тэтгэврийн даатгал		79,423,192.62	105,551,335.74
210202	Тэтгэмжийн даатгал		9,343,905.00	12,354,959.40
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,537,170.68	6,765,899.70
210204	Ажилгүйдлийн даатгал		3,996,710.94	6,749,899.50
210205	Эрүүл мэндийн даатгал		16,946,438.96	24,626,262.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		293,656,096.12	320,296,595.00
210401	Бичиг хэрэг		109,552,165.00	58,966,840.00
210402	Тээвэр, шатахуун		12,835,000.00	16,506,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		26,990,951.12	29,612,489.00
210404	Ном, хэвлэл		45,000,000.00	26,175,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		-	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		97,712,980.00	96,341,031.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		1,565,000.00	92,335,235.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>		-	935,524.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		-	935,524.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		25,180,500.00	24,896,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		18,550,000.00	-
210604	Урсгал засвар		6,630,500.00	24,896,750.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		295,348,942.14	244,913,306.01
210701	Гадаад албан томилолт		159,740,876.00	138,673,783.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		135,608,066.14	106,239,523.01
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		2,276,628,445.14	2,623,814,061.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,263,904,493.14	2,614,903,853.04
210803	Даатгалын үйлчилгээ		1,100,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар		69,752.00	297,208.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		-	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		11,554,200.00	8,569,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		484,343,485.99	682,138,993.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		320,940,063.00	518,565,336.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		50,335,000.00	37,925,952.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		113,068,422.99	125,647,705.18
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		1,310,757,220.00	128,463,840.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		1,306,786,000.00	80,978,100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		50,000,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		1,127,300,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		129,486,000.00	80,978,100.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		-	47,485,740.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		-	47,485,740.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		3,971,220.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,971,220.00	-
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3</b>	<b>5,690,305,098.59</b>	<b>5,442,270,416.89</b>
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>		<b>651,420,641.02</b>	<b>(887,194,209.16)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>		<b>651,420,641.02</b>	<b>(887,194,209.16)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>		<b>6,180,017,885.61</b>	<b>4,507,818,448.73</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>4,200,000.00</b>	<b>37,415,940.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		4,200,000.00	37,415,940.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>		4,200,000.00	37,415,940.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,200,000.00	37,415,940.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>6,175,817,885.61</b>	<b>4,470,402,508.73</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		1,427,300,000.00	346,749,416.01
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,427,300,000.00	346,749,416.01
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>		4,748,517,885.61	4,123,653,092.72
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		4,748,517,885.61	4,123,653,092.72
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>6,180,017,885.61</b>	<b>4,507,818,448.73</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>6,180,017,885.61</b>	<b>4,507,818,448.73</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>4,868,970,665.61</b>	<b>4,377,619,608.73</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		892,734,774.11	1,261,682,562.39
210101	Үндсэн цалин		500,856,888.25	624,420,313.54
210102	Нэмэгдэл		139,702,168.86	249,616,928.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт		156,228,000.00	251,091,242.12
210104	Урамшуулал		80,517,717.00	63,821,420.67
210105	Гэрээт ажлын хөлс		15,430,000.00	72,732,657.11
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		110,838,603.10	156,071,929.29
210201	Тэтгэврийн даатгал		75,606,391.39	105,574,908.69
210202	Тэтгэмжийн даатгал		8,898,804.86	12,354,959.40
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,441,321.16	6,765,899.70
210204	Ажилгүйдлийн даатгал		4,351,737.19	6,749,899.50
210205	Эрүүл мэндийн даатгал		17,540,348.50	24,626,262.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		227,064,011.12	173,797,925.00
210401	Бичиг хэрэг		45,131,970.00	26,204,910.00

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун		15,895,000.00	13,346,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		26,990,951.12	29,612,489.00
210404	Ном, хэвлэл		50,000,000.00	22,425,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		-	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		89,046,090.00	81,849,526.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>56,626,100.00</b>	<b>67,253,530.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		40,340,600.00	29,353,900.00
210604	Урсгал засвар		16,285,500.00	37,899,630.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>295,348,942.14</b>	<b>250,498,306.01</b>
210701	Гадаад албан томилолт		159,740,876.00	136,622,608.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		135,608,066.14	113,875,698.01
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>2,798,040,172.14</b>	<b>2,149,312,643.04</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,767,766,220.14	2,140,402,435.04
210803	Даатгалын үйлчилгээ		1,100,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар		69,752.00	297,208.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		-	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		29,104,200.00	8,569,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>488,318,063.00</b>	<b>319,002,713.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		437,983,063.00	281,076,761.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		50,335,000.00	37,925,952.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>1,311,047,220.00</b>	<b>130,198,840.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>1,307,076,000.00</b>	<b>82,713,100.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		50,000,000.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		1,127,300,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		129,776,000.00	82,713,100.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>		<b>3,971,220.00</b>	<b>47,485,740.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,971,220.00	47,485,740.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	82,518,632.00	915,191.00	585,461,652.23	668,895,475.23
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>82,518,632.00</b>	<b>915,191.00</b>	<b>585,461,652.23</b>	<b>668,895,475.23</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	651,420,641.02	651,420,641.02
8	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>82,518,632.00</b>	<b>915,191.00</b>	1,236,882,293.25	1,320,316,116.25
9	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>82,518,632.00</b>	<b>915,191.00</b>	1,236,882,293.25	1,320,316,116.25
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>82,518,632.00</b>	<b>915,191.00</b>	<b>1,236,882,293.25</b>	<b>1,320,316,116.25</b>
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(887,194,209.16)	<b>(887,194,209.16)</b>
17	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>82,518,632.00</b>	<b>915,191.00</b>	<b>349,688,084.09</b>	<b>433,121,907.09</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	5,276,952,000.00	4,123,653,092.72	1,153,298,907.28	78.14
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	5,276,952,000.00	4,123,653,092.72	1,153,298,907.28	78.14
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,985,952,000.00	4,040,939,992.72	945,012,007.28	81.05
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,313,994,800.00	1,261,682,562.39	52,312,237.61	96.02
210101	Үндсэн цалин	628,000,000.00	624,420,313.54	3,579,686.46	99.43
210102	Нэмэгдэл	250,000,000.00	249,616,928.95	383,071.05	99.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	252,316,800.00	251,091,242.12	1,225,557.88	99.51
210104	Урамшуулал	110,945,300.00	63,821,420.67	47,123,879.33	57.53
210105	Гэрээт ажлын хөлс	72,732,700.00	72,732,657.11	42.89	100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	164,249,400.00	156,071,929.29	8,177,470.71	95.02
210201	Тэтгэврийн даатгал	111,689,600.00	105,574,908.69	6,114,691.31	94.53
210202	Тэтгэмжийн даатгал	13,139,900.00	12,354,959.40	784,940.60	94.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,765,900.00	6,765,899.70	0.30	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,749,900.00	6,749,899.50	0.50	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,904,100.00	24,626,262.00	1,277,838.00	95.07
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	257,055,700.00	173,797,925.00	83,257,775.00	67.61
210401	Бичиг хэрэг	57,400,000.00	26,204,910.00	31,195,090.00	45.65
210402	Тээвэр, шатахуун	20,614,000.00	13,346,000.00	7,268,000.00	64.74
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,483,700.00	29,612,489.00	7,871,211.00	79.00
210404	Ном, хэвлэл	33,000,000.00	22,425,000.00	10,575,000.00	67.95
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	360,000.00	640,000.00	36.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	107,558,000.00	81,849,526.00	25,708,474.00	76.10
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	68,400,000.00	67,253,530.00	1,146,470.00	98.32
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	29,353,900.00	646,100.00	97.85
210604	Урсгал засвар	38,400,000.00	37,899,630.00	500,370.00	98.70
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	455,600,000.00	250,498,306.01	205,101,693.99	54.98
210701	Гадаад албан томилолт	243,000,000.00	136,622,608.00	106,377,392.00	56.22
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	212,600,000.00	113,875,698.01	98,724,301.99	53.56
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,202,452,100.00	1,812,633,027.03	389,819,072.97	82.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,187,250,000.00	1,803,722,819.03	383,527,180.97	82.47
210803	Даатгалын үйлчилгээ	2,600,000.00	-	2,600,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600,000.00	297,208.00	302,792.00	49.53
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	44,000.00	6,000.00	88.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,952,100.00	8,569,000.00	3,383,100.00	71.69
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	524,200,000.00	319,002,713.00	205,197,287.00	60.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	424,800,000.00	281,076,761.00	143,723,239.00	66.17
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	99,400,000.00	37,925,952.00	61,474,048.00	38.15
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	291,000,000.00	82,713,100.00	208,286,900.00	28.42

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	291,000,000.00	82,713,100.00	208,286,900.00	28.42
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	131,000,000.00	-	131,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	160,000,000.00	82,713,100.00	77,286,900.00	51.70
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	5,276,952,000.00	4,161,069,032.72	1,115,882,967.28	78.85
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	5,276,952,000.00	4,123,653,092.72	1,153,298,907.28	78.14
132001	Орон нутгийн төсвөөс	5,276,952,000.00	4,123,653,092.72	1,153,298,907.28	78.14
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-	-	-
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	37,415,940.00	(37,415,940.00)	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	37,415,940.00	(37,415,940.00)	-
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>35.00</b>	<b>32.00</b>	3.00	91.42

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>336,679,616.01</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	336,679,616.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	336,679,616.01
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	336,679,616.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	336,679,616.01
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,069,800.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	10,069,800.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>346,749,416.01</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	346,749,416.01
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	346,749,416.01

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 30,410.0 мянган төгрөгийн 6 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Аудитаар залруулагдаагүй нийт 59,519.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 17,257.9 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт, 42,261.3 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 59,519.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингөөс 25,835.4 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
								Үүнээс					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аж ахуйн материал дансанд 428.2 мянган төгрөгийн эм боох, материал бүртгэсэн.	1	428.2	-	-	1	428.2	1	428.2	-	-	-	-
2	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн байна.	1	7,183.6	-	-	1	7,183.6	1	38,578.8	-	-	-	-
3	Бараа материалын дансанд орлого авч тайлагнаагүй, зардалд шууд бүртгэсэн байна.	1	5,361.5	1	5,361.5	-	-	1	5,361.5	-	-	-	-
4	Зураг төсөл, төсвийг зарлага болгож тайлагнасан	1	4,600.0	1	4,600.0			1	4,600.0				
5	Засварын зардлаар хийсэн шкаф, шүүгээг үндсэн хөрөнгөнд орлого аваагүй байна	1	3,500.0	1	3,500.0			1	3,500.0				
6	БҮТЭЭ-ийн хангамжийн материалыг эзэнжүүлж картлахгүйгээр зарлага болгож тайлагнасан байна	1	9,336.7	1	9,336.7			1	9,336.7				
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>30,410.0</b>	<b>4</b>	<b>22,798.2</b>	<b>2</b>	<b>7,611.8</b>	<b>6</b>	<b>30,410.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан шатахууны баримтгүй, өөр байгууллагын нэртэй и баримт хавсаргасан, жолоочийн замын хуудасгүй зэрэг нийт 11,825.9 мянган төгрөгийн шатахууныг нотлох баримтгүй зарлага гаргасан байна.	1	11,825.9	1	11,825.9	-	-	-	-	-	-	-	-	-
2	Ажилтныг томилолтоор ажилласан хугацаанд нь 1,400.0 мянган төгрөгийн хоол, унааны мөнгө давхардуулан илүү олгосон байна.	1	1,400.0	1	1,400.0	-	-	-	-	-	-	-	-	
3	Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор дутуу байсан 3,390.0 мянган төгрөгийн зөөврийн компьютерыг буруутай албан хаагчаас төлүүлэх, арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	3,390.0	1	3,390.0	-	-	-	-	-	-	-	-	
4	Төсвийн хөрөнгөөр 642.0 мянган төгрөгийн нэрийн хуудас хийлгэж, үрэлгэн зарцуулсан байна.	1	642.0	1	642.0	-	-	-	-	-	-	-	-	
5	Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлээгүй бичиг хэрэг, аж ахуйн материалын зардалд 3,930.2 мянган төгрөг, арга хэмжээний зардалд 16,672.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	20,602.4	-	-	-	-	1	20,602.4	-	-	-	-	
6	Хөтөлбөр, арга хэмжээний зардлын төсөвт 13,171.7 мянган төгрөгийн цай, хоолны	1	13,171.7	-	-	-	-	1	13,171.7	-	-	-	-	

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	зардал баталж байгаа нь төсвийн хөрөнгө үр ашиггүй, үрэлгэн зарцуулж байна.												
7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зарцуулаагүй, үйл ажиллагаандаа 8,487.2 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна	1	8,487.2					1	8,487.2				
	<b>Дүн</b>	<b>7</b>	<b>59,519.2</b>	<b>4</b>	<b>17,257.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>42,261.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
	<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>												
1	Тайлант онд цахим дэлгүүрээс худалдан авалтыг хийж гүйцэтгээгүй байна.	1	64,730.8			1	64,730.8	-					-
2	Сургалт сурталчилгаатай холбоотой зардалд 68,599.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулалтын үр дүнг үнэлээгүй байна.	1	68,599.8			-		1	68,599.8				-
3	Гадны улсад туршлага судлах, сургалт, семинар зохион байгуулахаар шийдвэр гаргаж, төлөөлөгч, ИТХ-ын болон бусад онцгой байдлын хэлтсийн албан хаагч зэрэг нийт 18 хүний гадаад томилолтын зардалд 76,756.6 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан байна.	1	76,756.6			-		1	76,756.6				-
4	Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад орлого, зарлагын таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 89 гүйлгээ, зардлын 20 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 2 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-			-		-				1	
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>210,087.2</b>					<b>3</b>	<b>210,087.2</b>	<b>1</b>			<b>0.0</b>



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 151/АД 126171

Улаанбаатар хот

НТАГ-2026/467/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим дэлгүүрт байршсан 64,730,800.00 (жаран дөрвөн сая долоон зуун гучин мянга найман зуун) төгрөгийн барааг бусад этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" заасантай тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй арга хэмжээг авч биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга А.Уранбилэг, ахлах нягтлан бодогч У.Чинзориг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

Я.АЛТАНЦЭЦЭГ

Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090299



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 152/А0126171

Улаанбаатар хот

НТАГ-2026/467/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сургалт сурталчилгаатай холбоотой зардалд 68,599,800.00 (жаран найман сая таван зуун ерэн есөн мянга найман зуун) төгрөгийг зарцуулж, зарцуулалтын үр дүнг үнэлээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" заасантай тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төсвийн хэмнэлтийг горимыг хэвшүүлээгүй, сургалтыг цахим хэлбэрт оруулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга А.Уранбилэг, ахлах нягтлан бодогч У.Чинзориг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

Я.АЛТАНЦЭЦЭГ

Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090301



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 153/А0126171

Улаанбаатар хот

НТАГ-2026/467/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадны улсад туршлага судлах, сургалт, семинар зохион байгуулахаар шийдвэр гаргаж, хурлын төлөөлөгч болон бусад онцгой байдлын хэлтсийн албан хаагч зэрэгт нийт 18 хүний гадаад томилолтын зардалд 76,756,600.00 (далан зургаан сая долоон зуун тавин зургаан мянга зургаан зуун) төгрөгийг зарцуулж, төсвийн үрэлгэн зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх" 6 дугаар зүйлийн 6.4.1.-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" заасантай тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Төсвийн хэмнэлтийг горимыг хэвшүүлээгүй, гадаад томилолтын зардлыг хязгаарлаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга А.Уранбилэг, ахлах нягтлан бодогч У.Чинзориг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090303



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 дугаар сарын 25

№ 34/АУ126/191

Улаанбаатар хот

НТАГ-2026/Н67/МН-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр 642,000.00 (зургаан зуун дөчин хоёр мянган) төгрөгийн нэрийн хуудас хийлгэж, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан 642,000.00 (зургаан зуун дөчин хоёр мянган) төгрөгийг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хурлын ажлын албаны дарга А.Уранбилэг, ахлах нягтлан бодогч У.Чинзориг нараар төлүүлж Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ. хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ч.Мэндсайханд хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
Н.БАТТОГОО

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110079



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 дугаар сарын 25

№ 35/АУ/26/191

Улаанбаатар хот

НТАГ-2026/467/НА-СЯА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтныг томилолтоор ажилласан хугацаанд нь 1,400,000.00 (нэг сая дөрвөн зуун мянган) төгрөгийн хоол, унааны мөнгө давхардуулан илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориолоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс,шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Илүү олгосон унаа, хоолны 1,400,000.00 (нэг сая дөрвөн зуун мянган) төгрөгийг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга А.Уранбилэг, ахлах нягтлан бодогч У.Чинзориг нараар төлүүлж Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ. хүү торгуулийн орлогын MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ч.Мэндсайханд хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

Я.АЛТАНЦЭЦЭГ

Н.БАТТОГОО

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110077



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 дугаар сарын 05

№ 36/А0126171

Улаанбаатар хот

НТАГ-2026/467/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан шатахууны баримтгүй, өөр байгууллагын нэртэй и баримт хавсаргасан, жолоочийн замын хуудасгүй зэрэг нийт 11,825,900.00 (арван нэгэн сая найман зуун хорин таван мянга есөн зуун) төгрөгийн шатахууныг нотлох баримтгүй зарлага гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Нотлох баримтгүй зарцуулсан 11,825,900.00 (арван нэгэн сая найман зуун хорин таван мянга есөн зуун) төгрөгийг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Ажлын албаны дарга А.Уранбилэг, ахлах нягтлан бодогч У.Чинзориг нараар төлүүлж Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ. хүү торгуулийн орлогын МN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ч.Мэндсайханд хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
Н.БАТТОГОО

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110075



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 02 дугаар сарын 25

№ 37/ А0186 171

Улаанбаатар хот

НТАГ-2026/467/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор дутуу байсан 3,390,000.00 (гурван сая гурван зуун ерэн мянган) төгрөгийн зөөврийн компьютерийг буруутай албан хаагчаас төлүүлэх, арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", 72 дугаар зүйлийн 4-д "Тооллогын комисс дараах үүрэгтэй", 5-д "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.7-д "Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бус ашигласан" заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дутаасан хөрөнгийн 3,390,000.00 (гурван сая гурван зуун ерэн мянган) төгрөгийг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хурлын ажлын албаны дарга А.Уранбилэг, ахлах нягтлан бодогч У.Чинзориг нараар төлүүлж

<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110081

Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан дахь НТАГ үү торгуулийн орлогын  
MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх  
Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн  
хурлын дарга Ч.Мэндсайханд хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН;**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР



Я.АЛТАНЦЭЦЭГ

АХЛАХ АУДИТОР



Н.БАТТОГОО

-----  
<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар